



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар A/17

Өмнөдэлгэр сум

Анги дэвших болон улсын шалгалт
зохион байгуулах комисс томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.3 дах заалт, Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А/425 дугаар тушаалын 4.2 дах заалт, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төвийн хамтран баталсан “Анги дэвших, улсын шалгалт зохион байгуулах удирдамж”, Аймгийн боловсролын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/31 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Анги дэвших болон улсын шалгалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай. Үүнд:

Комиссын дарга: Ж.Сугаррагчаа	(Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд: Г.Мөнхтунгалаг	(БУЗАН-ийн ахлагч)
Ө.Түмэннаст	(НУЗАН-ийн ахлагч)
С.Мөнхтогоо	(БАЗАН-ийн ахлагч)
Б.Наранчимэг	(АХЗАН-ийн ахлагч)
Д.Шижиртуяа	(Сургуулийн хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтан)
О.Бүрэнбаяр	(Математикийн багш)
С.Удвалцэцэг	(Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга)
Ч.Хишигтогтох	(Сургалтын менежер)
Д.Хажидмаа	(Эцэг эхийн төлөөлөл)
Нарийн бичгийн дарга: Ж.Наранцацрал	(Сургалтын менежер)

2. Анги дэвших болон улсын шалгалтыг Хэнтий аймгийн боловсролын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/31 тушаалаар баталсан хуваарийн дагуу зохион байгуулсугай.

3. Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төвийн хамтран баталсан "Анги дэвших, сургууль төгсөх шалгалт зохион байгуулах удирдамж" -ийг баримтлан анги дэвших болон сургууль төгсөх шалгалтыг нэгдсэн удирдлагаар ханган, аливаа ёс зүйн зөрчлөөс ангид ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

4. Анги дэвших, сургууль төгсөх шалгалтын материалыг хүлээн авах, олшруулах хийх зэрэгт нэгдсэн зохион байгуулалт хийж тайлан мэдээг 2025 оны 6-р сарын 13-ны дотор нь тайлагнахыг комиссын нарийн бичгийн дарга (Ж.Наранцацрал)-д, шалгалтын дүн үнэлгээг тухайн өдөрт нь багтаан боловсролын мэдээллийн системд оруулахыг комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.СУГАРРАГЧАА

